

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 21/01

Улаанбаатар хот

КОМПАНИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 04 сарын 12-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь даатгал ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ЗОЛБАЯР

Санхүүгийн тайлан үйл ажиллагааны талаарх дүгнэлт

“Бодь Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2020 онд Монгол улсын бодит эдийн засаг эхний улиралд -10.7% буурч, оны эцэсрүү бага зэрэг сэргэж жилийн дүнгээр -5.3% гарлаа. Даатгалын салбарын цэвэр хураамж 4%-иар буурсан жил боллоо.

Бодь даатгалын хувьд дараах гол үзүүлэлттэй гарсан байна. Цэвэр хураамжийн орлого 4.5% өсч 14.7 тэрбум хүрсэн нь салбарын 11.7% эзэлж байна (+1% өнгөрсөн оноос). Үүнээс ойролцоогоор 45% орчим дараа жилд нөөцөлж, өмнөх оны нөөцөөс орлогод тооцон авч нийт 14.76 тэрбум төгрөг орлогод тооцож авсан байна.

Даатгуулагчийн хураамжийг нөхөн төлбөрт нөөцлөх хугацаанд олсон хөрөнгө оруулалтын орлогын өгөөж 13.2% байна. 2019 онд мөн ойролцоо 13% байсан. Цэвэр хөрөнгө 8%-иар өсч, давхар даатгагчтай холбоотой тооцоог оруулсан нийт хөрөнгө 0.3% буурсан байна.

Давхар даатгал орсон нийт хураамж 33.82 тэрбум буюу салбарт хамгийн өндөр 17% орчим эзэлж байна. Давхар даатгалд зуучилсан хураамжаас авсан комиссын орлого 29% өсч 1.16 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт давхар даатгалын комиссын орлогын 70% гаруй хувийг эзэлсэн байна. Мөн томоохон гэрээнүүдийн өөрийн хариуцах хэсэг 5% орчим болж өссөн байна.

Нийт нөхөн төлбөр 8.1 буюу салбарт хамгийн өндөр байна. Үүнээс манай өөрийн хариуцсан хохирлын орлогод эзлэх харьцаа 45% байгаа нь салбарын уг харьцаагаас 5% нэгжээр өндөр байна. Цэвэр төлсөн нөхөн төлбөр 2021 онд эдийн засаг саарсан боловч 5.5 тэрбумаас 6 тэрбум болж 10%-иар өссөн. Үүний 10% орчимоор нэхэмжлэл үүсэх боломжтой нөхөн төлбөрт зориулсан нөөц санг нэмэгдүүлж нийтдээ 6.6 тэрбум төгрөг зардалд тооцсон.

Иргэд, байгууллага, орон нутагт өргөн хүрээгээр ажилладаг тул үйл ажиллагааны зардлын харьцаа салбарын дунджаас бага зэрэг илүү байгаа боловч, зуучлалын зардлын харьцаа салбарын дунджаас бага байгаа тул нийтдээ зардлын харьцаа салбарын дунджаас 3% нэгжээр доогуур байна.

Ингээд үр дүнд нь цэвэр ашиг өнгөрсөн онд салбарын 10%-ийг эзэлж байсан бол 11%-ийг эзэлж байна. ТУЗ-ийн зүгээс компанийг зорьсон ашиг орлогодоо хүрээгүй, дунд түвшинд ажилласан гэж дүгнэж байна.

Ашиг, орлогод:

- Өндөр, дунд орлоготой иргэдэд зориулсан тээврийн хэрэгслийн даатгал, дунд орлоготой иргэдэд зориулсан эрүүл мэндийн даатгал шинээр нэвтрүүлсэн,
- Үйл ажиллагаа, нөхөн төлбөрийг цахимаар явуулсан,

- Олон улсын эрүүл мэндийн даатгалын эрэлт өссөн зэрэг хүчин зүйлс эерэгээр нөлөөлсөн байна.
- Мөн 2020 оны 6 сард амжилттай IPO хийж нээлттэй хувьцаат компани болсон нь компанийн нэр хүнд, санхүүгийн байдлыг өргөжүүлсэн үйл явдал боллоо.

Ашиг, орлого төлөвлөлтөд хүрээгүйд:

- Эдийн засгийн тодорхойгүй байдлаас үүдэн тэлэлтийн төлөвлөгөөг хойшлуулсан.
- Банкы эрсдэлтэй холбоотой даатгалыг зогсоосон,
- Бизнесийн байгууллагууд, айл өрхүүд мөнгөн хөрөнгөө нөөцөлж, даатгалын эрэлт саарсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

Цаашид, Дэлхийн банк, валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг хөгжлийн агентлагууд болон монгол банк ирэх онуудад бодит эдийн засаг 5% орчим өсөх, 2018 оны түвшиндээ хүрэх өөдрөг төсөөлөлтэй байгаа, манай компани бизнесийн олон суваг, давхар даатгалтай хамтын ажиллагаа сайн байгаа тул бизнесийн тэлэх төлөвлөгөө хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэн ТУЗ-ийн хурлаар дэмжсэн байгаа болохыг энд дурьдъя. Өргөжилтийн үр өгөөжөөр цаашид ашгийн маржин хурдтай өсөх боломжтой гэж үзэж байгаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ